



## **ГАРЧИГ**

Мэндчилгээ	2
“Шарын гол” ХК-ийн танилцуулга	4
ХЭХ-ын бэлтгэл төлөвлөлт цаг хугацааны график	5
ТУЗ-ийн хурлын тогтоол	8
ХЭХ-ын үйл ажиллагааны дараалал	11
ХЭХ-ын тооллогын комиссын тогтоол	12
Хуралд хэлэлцэх асуудал	13
ХЭХ-ын дэг	14
2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан	15
2017 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан	28
Компанийн засаглал, ТУЗ-ийн ажлын тайлан	40
ТУЗ-ийн хурлын тогтоол	49
ХЭХ-ын тогтоол /төсөл/	50
ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв /төсөл/	54
“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга	55
ХЭХ-ын тогтоол /төсөл/	60
ТУЗ-ийн хурлын тогтоол	61
Санал авах хуудас	62

## МЭНДЧИЛГЭЭ



Монгол улс, бүс орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулан, оюун ухаан хүч хөдөлмөрөө зориулж, үндсэн үүргээ биелүүлсээр ирсэн тус компанийн нийт уурхайчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллага хамт олон та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд хүрч ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хямралыг даван туулж буй энэ цаг үед компанийн гол зорилго болсон дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болох хөгжлийн ирээдүйд чиглэсэн бодлого тодорхойлж боловсронгуй болгон түүнийг хэрэгжүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагаа чиглэж ирлээ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйлдвэрийн шинэчлэл, цаашдын үйл ажиллагааны өрнөлттэй уялдуулан зайлшгүй шаардлагатай байгаа машин техник үндсэн хөрөнгө худалдаж авах, түрээсээр авч ажиллуулах тухай үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудал, компанийн 2017 оны сүүлийн хагас, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсвийн талаарх санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийн тухай, удирдлага зохион байгуулалтын асуудал зэрэг онцгой чухал асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж удирдамжаар хангаж байлаа.

Тус компанийн 2016 оны үйл ажиллагааг үнэлж Монгол улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран шалгаруулдаг “ТОП-100 аж ахуй нэгж”-ээр шалгаруулсан нь бидний цаашдын ажилд урам зориг, эрч хүч нэмсэн даалгавар гэж үзэж байна.

Бидний цаашдын хөгжил дэвшилд хүрэх зорилго, зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, харилцагч түнш байгууллагууд, уурхайчид нийт хамт олны хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээс шалтгаалан, хүндрэл бэрхшээлийг даван туулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.БАТМӨНХ

## МЭНДЧИЛГЭЭ



*Хүндэт хувьцаа эзэмшигчид ээ.*

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчид та бид компанийн 2017 оны үйл ажиллагааны талаар тайлагнан хэлэлцэхээр ээлжит хурлаа хуралдах гэж байна.

2017 оны нүүрс олборлолтын төлөвлөгөө 119.4%, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 112,2%-иар биелүүлж, улс орныхоо хойд бүс буюу Дархан, Эрдэнэтийн эрчим хүчний үйлдвэрүүдийн хэрэгцээг ханган олборлосон нүүрснийхээ 75-80 хувийг эрчим хүчний хэрэглээнд нийлүүлж бусад үйлдвэрүүд, жижиг хэрэглэгчдийг нүүрсээр хангах үүргээ амжилттай биелүүллээ.

2017 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, үндсэн үүргээ биелүүлсэн амжилтаар Дархан-Уул аймгийн хэмжээнд Дархан-Уул аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимаас “Уул уурхайн Энтрепенер-2017”, Дархан-Уул аймгийн ажил олгогч эздийн холбооны нэрэмжит уул уурхайн салбарын “Шилдэг байгууллага” өргөмжлөл, Шарын гол сумын “Оны тэргүүний байгууллага”-аар тус тус шалгарч өргөмжлөгдсөн байна.

Нүүрс борлуулалтын хэмжээ өссөн шалтгаан нь шинэ харилцагчид, дулааны цахилгаан станцуудын хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байсан бөгөөд энэ нь сүүлийн 20 жилийн хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Гэвч уулын ажлын үндсэн үзүүлэлтийн нэг болох нийт хөрс хуулалтын төлөвлөгөө 86,0 хувийн биелэлттэй байгаа нь уулын ажлын цаашдын өрнөлтөд сөрөг нөлөөтэй гэдгийг тэмдэглэж байна. Энэ нь компани нийт борлуулалтынхаа 80 орчим хувийг зохицуулагдсан үнээр буюу өөрийн өртгөөс доогуур үнээр борлуулснаас мөнгөн хөрөнгийн дутагдалд орж хөрс хуулалтыг зохих түвшинд хийж чадахгүйд хүрч олон жилийн алдагдал нэмэгдсээр уулын ажлын нөхцөл хүндэрч байгаа, мөн банкны зээлийн эргэн төлөлт, нүүрс олборлолтын хэмжээ өсөхтэй холбогдуулан машин техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай байгаа зэргээс шалтгаалан санхүүгийн байдалд хүндрэл үүсч байна.

Бид 2018 онд 9.132.000мм<sup>3</sup> хөрс хуулж 1.063.833 мтн нүүрс олборлож 1.040.200 мтн нүүрс борлуулахаар төлөвлөж байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд энэхүү зорилго зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллагын санал зөвлөмж, идэвхитэй үйл ажиллагаа бөгөөд уурхайчин хамт олны сэтгэл, зүтгэл онцгой нөлөөтэй гэдгийг тэмдэглэж зорьсондоо хүрнэ гэдэгт итгэл төгс байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, уурхайчин хамт олон, бизнесийн түнш хамтран ажиллагсдадаа амжилт бүтээлээр арвин, аз хиймориор дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ “ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТБААТАР




### **“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. Нэр: “Шарын гол” ХК  
Үндсэн харьяалал: Монгол улс
2. Хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Санжинт баг  
Утас: 70372235 Факс: 70372235
3. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл “Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.
4. Улсын бүргэлийн гэрчилгээний дугаар 1910010009, регистерийн дугаар 2050374
5. Тус компани нь чулуун нүүрс олборлон Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц болон бусад гэрээт байгууллага, компаниудад нийлүүлдэг.
6. Компанийн эрх барих дээд байгууллага нь: Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана.

БАТЛАВ: ТУЗ-ИЙН ДАРГА

Б.БАТМӨНХ




“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
 ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан  
 хийгдэх ажил, цаг хугацааны график

№	Хуулийн эцсийн хугацаа	Төлөвлөж буй хугацаа	Хийгдэх ажил	Бэлдэх материалууд
1	Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор /2сарын20/ КТХ 46-5	2 сарын 19	Ногдол ашиг тараах эсэх шийдвэр гаргах /тогтоол гарна/	ТУЗ-ийн хурлаар ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, бүртгэлийн өдрийг тогтоон ХЭХ-д мэдээлнэ.
2	ТУЗ-ийн шийдвэрийг гарснаас хойш ажлын 1 өдрийн дотор СЗХ, МХБ-д мэдээлэх	2 сарын хурлаас хойш ажлын 1 өдрийн дотор	Ногдол ашгийн тухай ТУЗ-ийн тогтоолыг СЗХ, МХБ-д хүргүүлэх	ТУЗ-ийн хурлын тогтоолыг албан бичгээр СЗХ, МХБ-д хүргүүлж, цахим хуудсанд байрлуулах
3	Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна. КТХ 59-4, 60-3 /4 сарын 20. 40 хоног/	3 сарын 14	ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын шийдвэр гаргах /тогтоол гарна/	ТУЗ-ийн хурлаар ХЭХ-аар хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хурлын дарга, хуралд бэлтгэх комисс, тооллогын комисс томилж, саналын хуудасны агуулга загварыг батлах Хуралд дараахи асуудал хэлэлцэнэ. 1. Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах 2. Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах 3. Компанийн ТУЗ-ийн 2017 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах 4. Компанийн ТУЗ-ийн ердийн, хараат бус гишүүдийг сонгох 5. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл
4	ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор мэдээлэл хүргэнэ /3 сарын 16/	3 сарын 17	ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол бүхий мэдэгдлийг 3 сарын 17, 18 өдрүүд бямба, ням гариг учир 3 сарын 19-нд СЗХ, МХБ-д хүргүүлэх	Уг мэдэгдэлд: 1. Хурлын мэдэгдэл 2. ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр /тогтоол/ хавсралт 1.2.3 3. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа 4. Хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар 5. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлээс: хуралд оролцсон гишүүд,

				хурлаар хэлэлцсэн асуудлууд санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал, санал хураалтын дүн гаргасан шийдвэр бүхий баримт материал
5	ХЭХ-ыг хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5 хоног КТХ 60-4	3 сарын 14-с хойш 5 хоног буюу 3 сарын 19	ХЭХ-ын зар гаргах	ХЭХ-ын зайлшгүй орсон байх мэдээлэл /МХБ, өөрийн сайт, өдөр тутмын 2-оос доошгүй сонин/ 1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг 2. Бүртгэлийн өдөр 3. Хуралд хэлэлцэх асуудлууд, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам газар 4. Хурал хуралдуулах зар гаргах өдөр 5. Хурлын комиссын дарга, гишүүдийн утас, электрон хаяг, ажиллах цагийн хуваарь 6. Шаардлагатай бусад мэдээлэл
6	Бүртгэлийн өдрийг ХЭХ-ыг хурал хуралдуулах шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журмын 2-5-д зааснаар хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байна.	3 сарын 29 дахь өдөр	Бүртгэлийн өдөр /ХЭХ-ын анхны зар гарснаас хойш 10 дахь өдөр/  СЗХ-ны 244-р тогтоолоор 15-20 дахь өдөр байна.	- СЗХ-ны 2016 оны 7 сарын 27-ны өдрийн 244-р тогтоолоор батласан, “ХЭХ-ын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2.7-р заалтын дагуу 15 дахь өдөр буюу 4 сарын 03-ны өдрөөр тогтоов.
7	Давтан зар гаргах /эхний зар гарснаас хойш 15 хоногийн дараа/	4 сарын 03	Давтан зар гаргах	ХЭХ-ын анхны зар гарснаас хойш 15 хоногийн дараа зарыг давтан 4 сарын 03-нд гаргана.
8	Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт материалыг анх зар гарсан өдрөөс хойш 5 хоногт багтаан брокерт хүргэнэ	3 сарын 26-ны өдөрт багтана.	ХЭХ-ын баримт бичиг танилцуулах материалыг брокер диллерийн компаниудад гэрээний дагуу хүргүүлэх	- ХЭХ-д хэлэлцэх асуудал - Хурлаас гарах тогтоолын төсөл  ХЭХ-ын материалыг товхимол болгон хэвлүүлж ХЭ-д урьдчилан танилцуулах зорилгоор брокер диллерийн компаниудад хүргүүлж байрлуулна.
9	4 сарын 01/Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод, байдлын тухай журмын 2.2.3-д/	4 сарын 01-ээс өмнө	Жилийн үйл ажиллагааны тайланг СЗХ, МБХ-д хүргэх	

10	Жилийн эцсийн санхүүгийн /аудитын байгууллагаар баталгаажсан/ тайланг хүргэх /НББ-ийн хууль 10.3, аудитын тухай хууль 10.2.1/	4 сарын 10-аас өмнө	СЗХ, МБХ-д хүргүүлэх	Уг тайланг “Аудитын тухай хууль”-ийн 10.2.1-т заасан хугацаанд СЗХ, МБХ-д мэдээлэх
11	ХЭХ хуралдах 4 сарын ..... КТХ 59-4	4 сарын 26	ХЭХ хуралдуулах	Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сард багтаана
12	ХЭХ-ын материал СЗХ, МБХ-д хүргэх /ҮЦЗЗТХ-ийн 20.1.8/	5 сарын 1-ний дотор	ХЭХ-ын материал шийдвэрийн хамт СЗХ, МБХ-д хүргүүлэх	СЗХ-ны 2012.02.15-ны тогтоол дугаар 34-өөр баталсан “ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх тухай” журмын 2.10-д заасан хугацаа 6 сарын 1-ээс өмнө. УИХ-ын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 20.1.8-д заасан хугацаа ХЭХ хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор СЗХ, МБХ-д хүргүүлэх

График төлөвлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

  
Л.Батсуурь



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 3 сарын 14 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Г  
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2, 3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 15<sup>30</sup> цагаас “Корпорейт хотел энд конвеншн центр” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
  - а) Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах, ТУЗ-ийн ажил, засаглалын тайланг мэдээлэх.
  - б) Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах
  - в) Компанийн ТУЗ-ийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
  - г) Компанийн ТУЗ-ийн хараат, хараат бус гишүүдийг сонгох
  - д) Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл
3. Хурал хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдрийг 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрөөр тогтоосугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хавсралт 1-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон танилцах бичиг баримтын жагсаалтыг хавсралт 2-оор, хэвлэл мэдээллээр зарлах хурлын зарыг хавсралт 3-аар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/, СТХ /Л.Даваасүрэн/ нарт даалгасугай.



7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар, ТУЗ-ийн дарга Б.Батмөнхийг томилсугай.
8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.  
Үүнд: Комиссын дарга: – Б.Батмөнх - ТУЗ-ийн дарга  
Комиссын гишүүн: - Жеймс Пассин - ТУЗ-ийн гишүүн  
Б.Батбаатар - ТУЗ-ийн гишүүн  
Д.Байлхүү - ТУЗ-ийн гишүүн  
Л.Батсуурь - - ТУЗ-ийн н/б дарга
9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.  
Үүнд: Комиссын дарга: – Б.Отгонзул – Дэд захирал  
Л.Оюундарь – Эдийн засагч  
Уранбайгаль – Би Ди Сек-ийн менежер
10. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны график төлөвлөгөө гаргаж, зохих хууль журмын дагуу хуралдуулахыг комисс /Б.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын  
комиссын бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын 9 дахь заалтаар томилсон тооллогын комиссын дарга Б.Отгонзул нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвших болсныг тэмдэглээд:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн санал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Б.Отгонзулыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаас чөлөөлсүгэй.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Л.Оюундарийг тооллогын комиссын даргаар, эдийн засагч Х.Уянгыг тооллогын комиссын гишүүнээр тус тус томилж, бүрэлдэхүүнийг өөрчилсүгэй.

ДАРГА



Б.БАТМӨНХ

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын үйл ажиллагааны дараалал**

2018.04.26

д/д	Үйл ажиллагаа	Хариуцагч
1.	Хуралд оролцох хувьцааг бүртгэн нэгтгэж хуралд мэдээлэл бэлтгэх	Тооллогын комисс Л.Оюундарь
2.	ХЭ-ийн хурлын бэлтгэл ажлын төлөвлөгөө, графикийн дагуу хийгдсэн ажил, гүйцэтгэлийг мэдээлэх	ТУЗ-ийн н/б дарга Л.Батсуурь
3.	Хуралд ирсэн хувьцааны бүртгэлийн дүн бүхий тооллогын комиссын тогтоол танилцуулах	Тооллогын комисс Л.Оюундарь
4.	ХЭ-ийн хурал нээх	Хурлын дарга Б.Батмөнх
5.	ХЭ-ийн хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга Б.Батмөнх
6.	Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Ерөнхий инженер Ж.Эрдэнэбат
7.	Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Ерөнхий нябо Л.Даваасүрэн Эдийн засагч Л.Оюундарь
8.	ТУЗ-ийн үйл ажиллагаа, компанийн засаглалын тайлан мэдээлэл	Хурлын дарга Б.Батмөнх
9.	Компанийн дүрэмд оруулах өөрчлөлт	Хурлын дарга Б.Батмөнх
10.	ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв	Хурлын дарга Б.Батмөнх
11.	Компанийн ердийн, хараат бус гишүүдыг сонгох	Хурлын дарга Б.Батмөнх
12.	Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон мэдээлэл	Хурлын дарга Б.Батмөнх Эдийн засагч Л.Оюундарь
13.	Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон ХЭ-ийн асуулт хариулт санал бодол	Хурлын дарга Б.Батмөнх Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
14.	Завсарлага, санал тоолж нэгтгэх	Тооллогын комисс Л.Оюундарь
15.	Санал хураалтын дүнг хуралд танилцуулах /тооллогын комиссын тогтоол/	Тооллогын комисс Л.Оюундарь
16.	ХЭ-ийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж батлуулах	ТУЗ-ийн н/б дарга Л.Батсуурь
17.	Хурал хаах	Хурлын дарга Б.Батмөнх

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 01

Улаанбаатар

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг  
хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67.3.1; 67.3.8; 69.1 дэх заалтууд компанийн дүрмийн 7.4.1-ийн 9 дэх заалт, тооллогын комиссын гаргасан ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг бүртгэн нэгтгэсэн дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хуралд нийт 10`170`242 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж ..... ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа бүгд ..... хувь болсныг хуралд мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... хувийн эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ДАРГА**

**Л.ОЮУНДАРЬ**

ХУРЛЫН ТОВ: 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 15:30 цагаас

ХУРЛЫН БАЙР: “Корпорейт хотел энд конвеншн центр” зочид буудлын хурлын танхимд

### **ХУРАЛД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
4. Компанийн ердийн хараат бус гишүүдийг сонгох
5. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл



**“Шарын гол” ХК-ийн хувьцаа  
эзэмшигчдийн хурлын дэг**

2018.04.26

Шарын гол

1. - Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах  
Гүйцэтгэх захирал – Б.Батбаатар  
Ерөнхий инженер – Ж.Эрдэнэбат  
/10 минут/
  - Компанийн 2017 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын тайлан  
Гүйцэтгэх захирал – Б.Батбаатар  
Ерөнхий нягтлан бодогч – Л.Даваасүрэн  
Эдийн засагч – Л.Оюундарь  
/10 минут/
    - Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл  
ТУЗ-ийн дарга – Б.Батмөнх  
/10 минут/
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах  
/10 минут/
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөв  
ТУЗ-ийн дарга – Б.Батмөнх  
/5 минут/
4. Компанийн ердийн хараат бус гишүүдийг сонгох  
/цаг тогтоохгүй/
5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон мэдээлэл  
ТУЗ-ийн дарга – Б.Батмөнх  
Эдийн засагч – Л.Оюундарь  
/5 минут/
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт хариулт  
/хүн тус бүр 3 минут/
7. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, санамж  
/хүн тус бүр 4 минут/
8. Завсарлага, санал тоолж нэгтгэх  
Тооллогын комисс  
/15 минут/
9. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоол танилцуулах  
Тооллогын комисс  
/цаг тогтоохгүй/
10. Хурлаас гарах шийдвэр /тогтоол/-ийг хэлэлцэж батлах  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга – Л.Батсуурь  
/цаг тогтоохгүй/

Хурлыг 2 цагт багтаана.

/Хэрэв шаардлагатай бол хуралдах хугацааг хэлэлцэн сунгаж болно/

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЛААРХ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ,  
ТУЗ-ИЙН АЖИЛ БОЛОН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**  
/ТУЗ-ийн дарга Б.Батмөнх/

**НЭГ. 2017 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ**


**1. Уулын ажлын гүйцэтгэл**

2017 оны уулын ажил компанийн ТУЗ-ийн хурлаар батлуулж АМГ-аар хянан баталгаажуулсан төлөвлөгөөний дагуу явагдсан бөгөөд 2017-2018 онд өвлийн оргил ачаалалтай үед олборлох нүүрсний нөөц нээн ачиж борлуулах, онд шилжих нүүрсний нөөц бэлтгэх, уурхайн уулын ажлын цаашдын өрнөлтийн чиглэлийг бататгах зэрэг үндсэн зорилтыг хангаж ажиллаа.

**Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэл**

д.д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он		2017 он Төлөвлөгөө, Гүйцэтгэлийн үзүүлэлт
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	761.9	764.2	912.3	119.4
2	Нүүрс борлуулалт	м.тн	753.7	821.8	909.3	110.6
3	Хөрс хуулалт	м.м3	4340.3	5419.0	4660.7	86.0
4	Тээвэртэй	м.м3	4102.3	4429	4170.1	94.2
5	Тээвэргүй	м.м3	238	990	490.6	49.6
6	Уулын цул	м.м3	4926.4	6006.8	5362.5	89.3
7	Шидэлт	м.м3	672.7	-	364.7	-
8	Өрөмдлөг	м.у.м	64.0	74.3	67.7	91.1
9	Х.Х.Коэффициент	м3/тн	5.69	7.09	5.11	-

Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэл, нүүрсний чанарын үзүүлэлт талбайн байрлал блок тус бүрээр



**Төвийн хойд блок**  
 төл. 1547.0 м.м<sup>3</sup> гүй. 611.1м.м<sup>3</sup>  
 төл. 0 м.тн гүй. м.тн  
 /олборлолт явагдаагүй/

**Хойд блок гарш**  
 төл. 894.0 м.м<sup>3</sup> гүй. 677.9 м.м<sup>3</sup>  
 төл. 344,4 м.тн гүй. 335,2 м.тн  
 2,59 2,02  
 Нүүрсний чанарын дундаж үзүүлэлтүүд:  
 • Чийг - 10,2-15,4%  
 • Үнслэг - 18,4-26,8%  
 • Дэгдэмхий - 40,3-44,9%  
 • Илчлэг - 3885 ккал

**Хойд блок**  
 төл. 1125.0 м.м<sup>3</sup> гүй. 858.9м.м<sup>3</sup>  
 төл. 0 м.тн гүй. м.тн  
 /олборлолт яваглаагүй/

**Төвийн урд блок**  
 төл. 2444.0 м.м<sup>3</sup> гүй. 2512,8 м.м<sup>3</sup>  
 төл. 565,2 м.тн гүй. 577,1 м.тн  
 4,31 4,35  
 Нүүрсний чанарын дундаж үзүүлэлтүүд:  
 • Чийг - 11,1-15,6%  
 • Үнслэг - 15,9-20,6%  
 • Дэгдэмхий- 40,7-44,5%  
 • Илчлэг - 4209 ккал


2017 онд харилцагчдад нийлүүлсэн нүүрсний дундаж үзүүлэлт 4079.9 Ккал/кг.

**2017 оны нүүрс борлуулалтын тоон болон график үзүүлэлтүүд**

Харилцагчдын ангилалаар

№	Харилцагч	2016 он			2017 он			Өөрчилөлт		
		дундаж үнэ	тонн	Үнийн дүн	дундаж үнэ	тонн	Үнийн дүн	тонн	тонн %	Үнийн дүн %
1	Эрчим хүч	36,524	588,612	21,498,493,745	36,506	652,383	23,816,029,270	63,771	10.80%	10.80%
2	VIP	55,762	97,741	5,450,247,869	54,584	218,735	11,939,400,134	120,994	123.80%	119.10%
3	Гэрээт: ЖДҮ	48,193	23,169	1,116,586,154	47,251	27,119	1,281,389,885	3,949	17.00%	14.80%
4	Гэрээгүй: Хувь хүн	80,000	2,931	229,683,200	79,898	3,554	283,967,570	623	21.30%	23.60%
5	Жижиглэн	78,855	39,100	2,585,734,400	48,689	3,634	176,942,125	-35,466	-90.70%	-93.20%
6	ШГ: Хямдралтай	42,402	3,916	166,041,377	41,895	3,927	164,507,177	11	0.30%	-0.90%
	<b>Дүн /тонн/</b>	<b>41,099</b>	<b>755,409</b>	<b>31,046,786,744</b>	<b>41,417</b>	<b>909,352</b>	<b>37,662,236,160</b>	<b>153,943</b>	<b>20.40%</b>	<b>21.30%</b>







### Шарын голын уурхайн нүүрсний геологийн нөөцийн хөдөлгөөний мэдээлэл

Ашиглалтын байдал	х/н	Үндсэн ордын баруун урд хэсэг	Үндсэн хэсэг	Баруун жигүүр	Шаазгайт	Усан сан бүхий хамгаалалтын бүсэд хамаарах нөөц	Үйлдвэрийн нөөц
2012.4.12 байдлаар	м.тн	43389,6	28053,4	374,8	124402,6	30310,4	165909,9
2013-2016 онд ашигласан	м.тн		3008,5				
2017 онд ашигласан	м.тн		912,2				
2018.01.01 байдлаар	м.тн	43389,6	24132,7	374,8	124402,6	30310,4	161989,3


Хойд блокийн гарш хэсгийн нүүрсний үеийн зүсэлт /2017-12-31 өдрийн байдлаар/



Төв блокийн урд хэсгийн нүүрсний үеийн зүсэлт /2017-12-31 өдрийн байдлаар/




### Нүүрс олборлолтын гүйцэтгэл /Сараар/



### Уулын тээврийн хэрэгслүүдийн тээвэрлэсэн хөрс, нүүрс /оноор/

Тээврийн хэрэгслийн төрөл	2016 он				2017 он				
	Нүүрс / мян.тн /	Хөрс / мян.м <sup>3</sup> /	Нийт цул / мян.м <sup>3</sup> /	Нийт цулд эзлэх хувь	Нүүрс / мян.тн /	Хөрс / мян.м <sup>3</sup> /	Нийт цул / мян.м <sup>3</sup> /	Нийт цулд эзлэх хувь	
HD465-7R	645.4	3391.9	3888.4	74.6	636.0	2770.3	3259.5	55.8	
БелАЗ	-	201.4	201.4	3.8	211.6	1660.5	1823.3	31.2	
түрээсний норд	149.7	625.2	740.4	14.2	179.3	472.0	609.9	10.5	
Өөрийн норд	102.9	305.4	384.5	7.4	75.3	90.1	148.0	2.5	
Бүгд	898.0	4523.9	5214.7	100.0	1102.2	4992.9	5840.7	100.0	
Нийт зарцуулсан түлш 1,701.0 мян.литр Нэгж зарцуулалт - 0.326 л/м <sup>3</sup>				Нийт зарцуулсан түлш 2,530.7 мян.литр Нэгж зарцуулалт - 0.433 л/м <sup>3</sup>					

## 2017 онд ажилласан тээврийн хэрэгслүүдийн дундаж гаралтын тоон үзүүлэлт /сараар/






	I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар	д/дамп тоо
—♦— коматцу	4.7	4.8	5.2	5.2	4.7	5.2	5.2	5.5	5.1	5.1	5.2	5.1	5.1
—■— Белаз	3.5		3.5	2.3	2.7	3.3	3.3	3.7	3.3	3.5	3.8	4.2	3.4
—▲— Түрээс	2.2	1.7	1.8	2.4	4.4						1.6	1.7	2.3
—×— Норд бенз	1	1.3	0.9	0.9									1
—*— сард ажилласан дампын тоо	11.4	7.8	11.4	10.8	11.8	8.5	8.5	9.2	8.4	8.6	10.6	11	9.8

## Техникийн ашиглалт засвар үйлчилгээ





**УУЛЫН ҮНДСЭН МАШИН МЕХАНИЗМЫН 2017 ОНЫ СЭЛБЭГ  
ЗАРЦУУЛАЛТ /сая. төг/**




**2017 оны тэсэлгээний ажлын үзүүлэлт**

Тэсэлсэн уулын цул мян.м <sup>3</sup>	АНФО /тн/			ЭМУЛЬС ф120 /тн/		
	төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	зөрүү
1619.0	621.0	320.9	- 299.7	416.0	345.2	- 70.8


**Тэсрэх бодсийн зарцуулалт, кг/м<sup>3</sup>**

**Тэсэлгээний ажлын өртөгийн харьцуулалт, төг/м<sup>3</sup>**

**Цахилгаан эрчим хүч хангамж**

Эрчим хүчний үнэ тариф			
Мөрдсөн хугацаа	Ангилал		Тариф /төг/квтц/
2015.07.06	Өдрийн хэрэглээ	06.00 - 17.00	155.90
	Оройн хэрэглээ	17.00 - 22.00	276.00
	Шөнийн хэрэглээ	22.00 - 06.00	77.10
2017.07.17	Өдрийн хэрэглээ	06.00 - 17.00	167.78
	Оройн хэрэглээ	17.00 - 22.00	287.88
	Шөнийн хэрэглээ	22.00 - 06.00	88.98



Уулын үйлдвэрлэлийн сайжруулалтын ажлуудын зураг

Дотоод овоолго үүсгэж хөрс хуулалтын ажлыг богино замыг ашиглан техникийн бүтээлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан./отвол 6/



**Аюулгүй ажиллагаа, байгаль орчин**


Тохиолдлын бүртгэл /2015-2017 он/				
№	Осол зөрчлийн ангилал	2015	2016	2017
1	Үйлдвэрийн осол	3	5	2
2	Осолд дөхсөн тохиолдол	6	4	3
3	Эмнэлгийн тусламж авсан гэмтэл	1	5	3
4	Хугацаа алдсан гэмтэл	4	0	2
5	Авто ослын тохиолдол	2	3	3
6	Галын тохиолдол	2	1	3
7	Өмчийн эвдрэлийн тохиолдол	6	5	5
8	Архины зөрчил	21	16	9
Нийт		45	39	30

**ХАБЭА–н удирдлагын тогтолцоог нэвтрүүлж хэвшүүлэх чиглэлээр хийгдсэн ажил**

№	Үйл ажиллагааны чиглэл	Хийгдсэн давтамж	Гүйцэтгэлийн тоо хэмжээ
1	Мэргэжлийн байгууллагуудын сургалт	7 удаа	100 хүн
2	Нийт ажилтны болон ИТА нарын сургалт	14 удаа	550 хүн
3	ХАБ-н сэдэвт нийтийн уралдаан тэмцээн бусад арга хэмжээ	6 удаа	500 гаруй хүн
4	Аюулыг мэдээлэх хуудас арга хэмжээ	157 зөрчил илрүүлсэн	144 зөрчил арилгасан
5	Эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал	Тогтмол	114 ажлын байр
6	Үзлэг хяналт шалгалт	279 удаа	235 зөрчил илрүүлсэн
7	Хамгаалах хэрэгслийн хангалт	45 төрлийн	97.9 сая төгрөг
8	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал	Давхардсан тоогоор	10142 хүн
9	Боловсруулсан дүрэм журам	жилдээ	22
10	Сарын сэдэвт аян	сар бүр	12 удаа

**ХАБЭА-н чиглэлээр хийгдсэн ажлын зураг**



**Байгаль орчин хамгаалал нөхөн сэргээлтийн ажлын үзүүлэлт**

№	Үзүүлэлт		Тоо хэмжээ
1	Хэмжилт эсгэлт шинжилгээ	Агаар	6
		Ус	6
		Хөрс	6
		Цацраг	3
2	Сургалт		22 ажилтан
3	Үзлэг хяналт		38 удаа
4	Албан мэдэгдэл		37 удаа
5	Нөхөн сэргээлт		6.9 га, 1.610м
6	Гадна орчны цэвэрлэгээ, Шарын голын цэвэрлэгээ		2 удаа, 1 удаа
7	Байгаль орчны хүрээнд тарьсан мод		400 гаруй





## ⇒ ХҮНИЙ НӨӨЦ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТАЛААР

### Ажиллах хүчний тухай үзүүлэлт

Ажилчдын тоо:


- Удирдлага - 22
- Иженер техникийн ажилчид - 55
- Ажилчид - 360




Эрэгтэй, эмэгтэй ажилчдын тоо:

- Эрэгтэй – 338
- Эмэгтэй - 99


### Ажиллагсдын нас



### Ажилласан жил





### Боловсрол



### 2017 оны сургалтын ажил

Төрөл	Чиглэл	Тоон үзүүлэлт	Зардал /сая төгрөг/
Гадны сургалт	Мэргэжлийн болон ХАБЭА-н чиглэлээр	15 удаа сургалт зохион байгуулсан	14.0
Дотоод сургалт	ХАБ, эрүүл мэнд, хууль эрх зүй болон мэргэшүүлэх чиглэлээр	61 удаагийн сургалтанд 8177 хүн хамрагдсан	



### Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны талаар

Шалгагдсан чиглэл хяналтын хуудасны дугаар	2017 оны 2-р сард хийгдсэн шалгалтаар авсан үнэлгээ	2017 оны 9-р сард хийгдсэн гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээ
Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах ХХ-2,8	21,6% “Бага эрсдэлтэй”	15% “Бага эрсдэлтэй”
Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн үйл ажиллагааг шалгах ХХ-5.29	55% “Их эрсдэлтэй”	32,% “Дунд эрсдэлтэй”
Ил уурхайн үйл ажиллагааг шалгах ХХ-2.6	10% “Бага эрсдэлтэй”	7,3% “Бага эрсдэлтэй”
Авто зам, замын байгууламжийн үйл ажиллагааг шалгах ХХ-5,17	67,5% “Их эрсдэлтэй”	37,5% “Дунд эрсдэлтэй”
Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгах ХХ-2.12	43,6% “Дунд эрсдэлтэй”	6,0% ”Бага эрсдэлтэй”
Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах ХХ-4.1.1	28,9% “Дунд эрсдэлтэй”	19,4% “Бага эрсдэлтэй”
Савалсан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах ХХ-5.28.1	55,0 “Их эрсдэлтэй”	34,6% “Дунд эрсдэлтэй”
Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах ХХ-4.2	Шалгалт хийгдээгүй	9,9% “Бага эрсдэлтэй”
Барилга байгууламжийн ашиглалтыг шалгах ХХ-5,2	45% ”Дунд эрсдэлтэй”	-
Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах ХХ-	31% “Дунд эрсдэлтэй	-
Хөдөлмөрийн харилцааг шалгах ХХ-4,6	34% ”Дунд эрсдэлтэй”	-

Дотоод хяналтаас хийгдсэн үзлэг шалгалтын үзүүлэлт			
д/д	Хяналтын чиглэл	Шалгалт тоо	Зөрчил тоо
1	Байгаль орчны нөлөөллийн хяналт	3	18
2	Ажил үйлчилгээ бүтээгдэхүүний чанарын хяналт	4	35
3	Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагааны хяналт	12	74
4	Ажлын цаг ашиглалт , хөдөлмөрийн сахилга батын хяналт	4	9
5	Өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт , хамгаалалтын хяналт	5	10
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил , харуул хамгаалалтын хяналт	18	33
	Дүн	46	179

## ХОЁР. 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТОВЧ

- Тайлант онд 764.2 м.тн нүүрс олборлож, 821.9 м.тн нүүрс борлуулах зорилт тавин ажилласан бөгөөд гүйцэтгэлээр 912.3 м.тн нүүрс олборлож, 909.4 м.тн нүүрс борлуулж борлуулалтын төлөвлөгөө 10.6 хувиар давж биелэсэн үзүүлэлттэй гарсан. Нүүрсний борлуулалтын биет хэмжээ 20.7%-иар өссөнөөс үнийн дүнгээр 6,314.8 сая төгрөгний орлого нэмэгджээ.
- 2017 оны алт олборлох зардлын төсвийг 7,201.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 4,982.0 сая төгрөгний зардал гарган ажилласан нь 2,219.8 сая төгрөгөөр зардлыг бууруулж, алтны орлого 10,430.3 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Өмнөх онд ханшны зөрүүний ашиг, алдагдлаас 4,963.6 сая төгрөгийн алдагдлыг хүлээж байсан бол тайлант онд 177.9 сая төгрөгний ашигтай гарсан
- Өмнөх онтой харьцуулахад мөнгөн орлогын төвлөрөлт нэмэгдэж байгууллагад төлөх зарим хуримтлагдсан өр төлбөрүүдийг барагдуулж ажилласан.
- ТУЗ-ийн тогтоолын дагуу компанийн бүтцэд өөрчлөлт орсоноос 32 ажилтанг орон тооны цомхотголд оруулж цалингийн зардлыг 102.9 сая төгрөгөөр бууруулсан.
- Нүүрс олборлолтын хэмжээгээ нэмэгдүүлэх зорилгоор HITACHI EX 1200-6 экскаватор, 7555 маркын 8 ш Белаз, Liebherr 724 бульдозер, Комаци D375 бульдозер зэрэг 6,411.4 сая төгрөгний үндсэн хөрөнгө худалдан авсанаар олборлолтын хэмжээ 19.7%-иар нэмэгдсэн.
- Хойшлуулсан хөрс хуулалтын хөрөнгийн хорогдлыг зардлаар хүлээн зөвшөөрсөнөөр зардал 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.



**САНХҮҮГИЙН ТАЙЛАН, САЯ ТӨГРӨГ /Аудитлагдаагүй/**

	Балансын зүйл	2016 он	2017 он	хувь	зөрүү
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
<b>1.1.1</b>	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	784.0	849.6		65.6
<b>1.1.2</b>	Дансны авлага	4,240.8	3,185.6		(1,055.2)
<b>1.1.3</b>	Бусад авлага	4,089.5	5,477.1		1,387.7
<b>1.1.4</b>	Бусад санхүүгийн хөрөнгө	814.8	229.4		(585.5)
<b>1.1.5</b>	Бараа материал	2,585.0	2,519.5		(65.6)
<b>1.1.6</b>	Урьдчилж төлсөн зардал тооцоо	385.7	832.4		446.8
<b>1.1.7</b>	Бусад эргэлтийн хөрөнгө	5.4	0.2		(5.1)
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>12,905.1</b>	<b>13,093.8</b>	<b>18.7%</b>	<b>188.8</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
<b>1.2.1</b>	Үндсэн хөрөнгө	35,109.1	35,167.0		58.0
<b>1.2.2</b>	Биет бус хөрөнгө	105.0	22.2		(82.8)
<b>1.2.3</b>	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,917.9	2,209.8		(708.1)
<b>1.2.4</b>	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	372.1	-		(372.1)
<b>1.2.5</b>	Бусад эргэлтийн бус хөрөнгө	21,484.1	19,447.7		(2,036.5)
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>59,988.2</b>	<b>56,846.7</b>	<b>81.3%</b>	<b>(3,141.5)</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,893.3</b>	<b>69,940.5</b>	<b>100.0%</b>	<b>(2,952.7)</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>				
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
<b>2.1.1.1</b>	Дансны өглөг	4,238.9	3,377.3		(861.5)
<b>2.1.1.2</b>	Цалингийн өглөг	491.4	494.2		2.8
<b>2.1.1.3</b>	Татварын өр	2,585.1	3,491.1		906.0
<b>2.1.1.4</b>	НДШ-ийн өглөг	877.2	370.6		(506.6)
<b>2.1.1.5</b>	Богино хугацаат зээл	11,531.1	15,378.6		3,847.5
<b>2.1.1.6</b>	Хүүний өглөг	1,939.7	3,642.5		1,702.9
<b>2.1.1.7</b>	Ногдол ашгийн өглөг	0.4	0.4		-
<b>2.1.1.8</b>	Урьдчилж орсон орлого	36.1	20.6		(15.5)
<b>2.1.1.9</b>	Бусад богино хугацаат өр төлбөр	6,147.1	3,708.2		(2,439.0)
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>27,846.9</b>	<b>30,483.4</b>		<b>2,636.5</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
<b>2.1.2.1</b>	Урт хугацаат зээл	8,555.7	-		(8,555.7)
<b>2.1.2.2</b>	Нөөц /өр төлбөр/	8,961.7	12,103.2		3,141.6
<b>2.1.2.3</b>	Хойшлогдсон татварын өр	240.5	666.0		425.5
<b>2.1.2.4</b>	Бусад урт хугацаат өр төлбөр	1,312.0	638.3		(673.7)
<b>2.1.2.5</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>19,069.9</b>	<b>13,407.5</b>		<b>(5,662.4)</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>46,916.8</b>	<b>43,890.9</b>	<b>62.8%</b>	<b>(3,025.9)</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>				
<b>2.3.1</b>	Төрийн өмч				
<b>2.3.2</b>	Хувийн өмч	1,017.0	1,017.0		-
<b>2.3.3</b>	Нэмж төлөгдсөн капитал	23,145.2	23,145.2		-
<b>2.3.4</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний	11,613.1	9,539.0		(2,074.1)
<b>2.3.5</b>	Хуримтлагдсан ашиг	(9,798.8)	(7,651.5)		2,147.2
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>25,976.5</b>	<b>26,049.6</b>	<b>37.2%</b>	<b>73.1</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>72,893.3</b>	<b>69,940.5</b>	<b>100.0%</b>	<b>(2,952.7)</b>

**ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /САЯ ТӨГРӨГ/**

	Үзүүлэлт	өмнөх оны дүн	тайлант оны дүн	Зөрүү
<b>1</b>	Үндсэн үйл ажиллагаа			
	Орлого	32,183.8	48,922.9	16,739.1
	нүүрс	30,595.9	36,904.8	6,308.9
	алт	1,587.9	12,018.1	10,430.2
	ББӨ	25,854.1	40,169.5	14,315.4
	нүүрс	24,701.4	35,187.5	10,486.1
	алт	1,152.7	4,982.0	3,829.3
	<b>Нийт ашиг</b>	<b>6,329.7</b>	<b>8,753.4</b>	<b>2,423.7</b>
	нүүрс	<b>5,894.5</b>	<b>1,717.3</b>	<b>(4,177.2)</b>
алт	<b>435.2</b>	<b>7,036.1</b>	<b>6,600.9</b>	
<b>2</b>	Удирдлага борлуулалтын зардал	5,865.5	3,095.9	(2,769.6)
	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>464.2</b>	<b>5,657.5</b>	<b>5,193.3</b>
<b>3</b>	Үйл ажиллагааны бус			-
	Хүүгийн орлого	10.6	18.4	7.8
	Бусад орлого	484.7	1,836.3	1,351.6
	Бусад зардал	3,220.5	4,903.0	1,682.5
	Түрээсийн орлого	27.3	23.5	(3.8)
	<b>ҮА-ны бусын алдагдал</b>	<b>(2,697.9)</b>	<b>(3,024.8)</b>	<b>(326.9)</b>
<b>4</b>	Валютын ханшны ашиг, алдагдал	(4,963.6)	177.9	5,141.5
<b>5</b>	Орлогын албан татвар		399.7	399.7
<b>6</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>(7,197.3)</b>	<b>2,411.0</b>	<b>9,608.3</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /САЯ ТӨГРӨГ/**

	Үзүүлэлт	өмнөх оны дүн	тайлант оны дүн	зөрүү
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>1.1</b>	Мөнгөн орлогын дүн (+)	33,042.4	42,969.3	9,926.9
<b>1.2</b>	Мөнгөн зарлагын дүн (-)	(28,284.9)	(35,796.4)	7,511.5
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,757.5</b>	<b>7,172.9</b>	2,415.4
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			-
<b>2.1</b>	Мөнгөн зарлагын дүн (-)			-
<b>2.1.1</b>	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд	(443.2)	(1,866.4)	1,423.1
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(443.2)</b>	<b>(1,866.4)</b>	1,423.1
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			-
<b>3.1</b>	Мөнгөн орлогын дүн (+)	301.3	0.1	(301.2)
<b>3.1.1</b>	авсан зээл	300.0		(300.0)
	валютын ханшны	1.3	0.1	(1.2)
<b>3.2</b>	Мөнгөн зарлагын дүн (-)	(4,299.3)	(5,241.0)	941.8
<b>3.2.1</b>	зээлийн төлөлт	(630.0)		(630.0)
<b>3.2.2</b>	валютын ханшны	(54.8)	(6.5)	48.3
<b>3.2.3</b>	Санхүүгийн түрээсийн төлөлт	(3,614.5)	(5,234.6)	1,620.1
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,998.0)</b>	<b>(5,240.9)</b>	1,242.9
	<b>Цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>316.3</b>	<b>65.6</b>	(250.7)
	<b>БМ эхний үлдэгдэл</b>	<b>467.7</b>	<b>784.0</b>	<b>316.3</b>
	<b>БМ эцсийн үлдэгдэл</b>	<b>784.0</b>	<b>849.6</b>	<b>65.6</b>

## 2017 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


### МӨНГӨН ХӨРӨНГӨ

- 2017 онд орсон мөнгөн урсгалын 11.4%-ийг алтны борлуулалтаас, Дархан ДЦС-аас 20.9%, Эрдэнэт ДЦС-аас 26.6%, Эрдэнэт ГОК-оос 30.4%, бусад байгууллагаас 10.7%-ийг бүрдүүлжээ. Эх үүсвэрийн хэмжээ тайлант онд 42,969.3 сая төгрөг гарсан нь урд онтой харьцуулахад 9,926.9 сая төгрөгөөр өссөн байна.
- Мөнгөн урсгалын 15.7%-ийг ажилчдын цалин хөлсөнд, сэлбэг материалд 12.5%-ийг, түлш шатахуун тос худалдан авахад 16.7%-ийг, татвар нийгмийн даатгалд 4.8%, санхүүгийн түрээст 12.2%-ийг тус тус зарцуулжээ.



### АВЛАГА

- Нийт авлагат нүүрсээр авах авлага 32.4%-ийг эзэлж байна. Албан байгууллага, хувь хүн, компаниудаас авах нүүрсний авлага оны эхэнд 4,381.4 сая төгрөг байсан ба үүний 867.7 сая төгрөг нь Эрчим хүчний системийн харьяа байгууллагуудаас авах авлага эзэлж байсан бол оны эцсийн байдлаар нүүрсний авлагын нийт дүн 3,125.5 сая төгрөг болсон ба үүнээс Дулааны станцуудаас авах авлага 1,134.9 сая төгрөг болж оны эхнийхээс 267.2 сая төгрөгөөр өссөн байна. Нүүрсний авлагын ихэнх хувийг Дархан ДЦС, Эрдэнэт ДЦС, Нако түлш ХХК эзэлж байна.

Авлагын төрлийг графикаар харуулбал:



Нүүрсний авлагын дүнд томоохон жин эзэлж буй компаниудыг графикаар харуулбал:



## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- Манай компани нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, машин механизмыг өрнөж байгаа уулын ажил, өсөн нэмэгдэж байгаа нүүрс олборлолтын ажилтай уялдуулан шинэчлэх бодлого баримталж ажиллаж ирсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор тайлант онд 6,411.4 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн.
- Үүнд: Нүүрс олборлолтын хэмжээгээ нэмэгдүүлэх зорилгоор HITACHI EX1200-6 экскаватор, 7555В маркын 8 ширхэг Белаз, Liebherr 724 бульдозер, Комацу D375 бульдозер авч хүчин чадлаа нэмэгдүүллээ.

Нэмэгдсэн хөрөнгийн жагсаалт:

д/д	хөрөнгийн нэр	тоо	сая төг	зориулалт
1	Белаз 7555 В автосамосвал	8	2,894.5	хөрс, нүүрс тээвэрлэх
2	Ланд-200	1	177.5	гүйцэтгэх захиралд
3	Тоёота Hiace	1	25.7	сэлбэг материал тээвэрлэх
4	компрессор S10K10	1	3.6	
5	насос ЦНС 300/240	1	60.0	гүний ус шүүрүүлэх
6	Hitachi EX 1200-6 экскаватор	1	2,602.6	
7	Liebherr 724 бульдозер	1	147.0	
8	Комatsu D375 бульдозер	1	488.6	
9	бусад		11.9	
	дүн		6,411.4	



Hitachi EX 1200-6 экскаватор



Liebherr 724 бульдозер



Белаз 7555 В /8ш/



Комацу D375





## НИЙТ ӨР ТӨЛБӨР

- 2017 оны эцэст нийт өр төлбөрийн 69.5%-ийг богино хугацаат өр төлбөр, 30.5%-ийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Нийт өр төлбөр оны эхнээс 3,025.8 сая төгрөгөөр буурчээ.

## БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

- **Дансны өглөг** – Бэлтгэн нийлүүлэгч байгууллага болон хувь хүмүүсийн ажил үйлчилгээгээр үзүүлсэн өглөгүүд оны эхнээс буурч, нийлүүлэгдсэн сэлбэг материалын өглөг өссөн байна.
- **Богино хугацаат зээл болон зээлийн хүү** - Урьд оны мөн үеэс богино хугацаат зээл болон хүүгийн төлбөрийн хэмжээ өссөн бөгөөд үүнд ЕСБХБанкны 2017 онд төлөгдөх зээл болон зээлийн хүүгийн төлбөр төлөгдөөгүй хуримтлагдсан нь гол нөлөөлөл болсон. 2017 онд шинээр зээл аваагүй. Зээлийн үлдэгдэл оны эхнээс 289.0 сая төгрөгний ханшийн тэгшитгэлээр буурсан.



- **Татвар, НДШ-ийн өглөг** - 10 нэр төрлийн татварт нийт 4,207.4 сая төгрөгийн ногдол, 3,301.1 сая төгрөгийн төлөлт хийгдсэнээр татварын өр оны эхний үлдэгдлээс 906.0 сая төгрөгөөр өсч, НДШ нь 506.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан. Татварын өрийн үлдэгдэлд ААНОАТатвар 296.4 сая төгрөг, НӨАТ 2,433.6 сая төгрөг, нөөцийн татвар 760.0 сая төгрөгөөр томоохон байрыг эзэлж байна.

- **Бусад өглөг -3,572.9** сая төгрөгт Санхүү болон үйл ажиллагааны түрээсийн өглөг болон санхүүгийн үүсмэл өр төлбөр багтаж байна.

### УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

- Тайлант хугацаанд Firebird компанийн зээлийн үлдэгдлийг бүрэн төлж дуусгасан ба ЕСБХБ-ны зээлийн үлдэгдэл нь ангилал шилжиж богино хугацаат өр төлбөрт бичигдсэнээр урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй болсон. Зээлийн хүүнд 285.6 мянган ам.долларын ногдол хийгдэж, 550.0 мянган ам.долларын төлөлт хийгдсэнээр зээлийн хүүгийн үлдэгдэл 262.7 мянган ам.доллар байна.

Харилцагч	2016.12.31	2017.12.31
<b>Зээл</b>		
Firebird SHG investment Pte Ltd	4,406.5	-
ЕСБХБ	4,149.2	-
<b>Дүн</b>	<b>8,555.7</b>	<b>-</b>
<b>Хүү</b>		
Firebird SHG investment Pte Ltd	1,312.0	638.3
<b>Дүн</b>	<b>1,312.0</b>	<b>638.3</b>

### БАРАА МАТЕРИАЛЫН ҮЛДЭГДЭЛ

- Оны эцэст бараа материалын үлдэгдэл 2,519.7 сая төгрөг гарсан нь оны эхнээс бараа материалын үлдэгдэл 70.7 сая төгрөгөөр буурсан. Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл буурч, сэлбэг материалын үлдэгдэл 654.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

№	Төрөл	Эхний үлдэгдэл	орлого	зардал	Эцсийн үлдэгдэл	зөрүү (+,-)
			дүн	дүн		
1	Түүхий эд материал	68.4	131.3	90.1	109.7	41.2
2	Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл	1,183.2	33,660.1	34,493.9	349.5	(833.8)
3	Хангамжийн материал	95.6	677.8	632.9	140.4	44.9
4	Дизель түлш	125.9	6,063.0	6,092.4	96.5	(29.4)
5	Шатахуун ба шингэн түлш	-	18.4	18.4	-	-
6	Тос, тослох материал	56.8	1,250.5	1,206.0	101.3	44.5
7	Сэлбэг материал	505.5	845.7	842.8	508.5	3.0
8	Тээврийн хэрэгслийн сэлбэг	523.6	4,047.3	3,393.2	1,177.6	654.0
9	Хөдөлмөр хамгаалал	25.9	104.1	94.1	35.9	10.0
	<b>ДҮН</b>	<b>2,585.0</b>	<b>46,798.3</b>	<b>46,863.8</b>	<b>2,519.5</b>	<b>(65.6)</b>
10	Мал амьтад	5.4	4.6	9.7	0.2	(5.1)
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,590.4</b>	<b>46,802.8</b>	<b>46,873.5</b>	<b>2,519.7</b>	<b>(70.7)</b>

## БОРЛУУЛАЛТ, БОРЛУУЛСАН БАРААНЫ ӨРТӨГ

### ОРЛОГО

- Компани тайлант онд 51,902.9 сая төгрөгний борлуулалт хийснээс нүүрсний борлуулалтаас 71.1%, алтны борлуулалтаас 23.2%, ханшны зөрүүнээс 2.1%, бусад борлуулалтаас 3.6%-ийг олсон байна.

Орлогын төрлөөр нь авч үзвэл:

д/д	орлогын нэр төрөл	2016 он		2017 он		зөрүү сая.төг
		сая.төг	хувь	сая.төг	хувь	
1	Нүүрсний орлого	30,595.9	90.6	36,904.7	71.1	6,308.8
2	алтны орлого	1,587.9	4.7	12,018.1	23.2	10,430.2
3	үйлдвэрийн бусын орлого	82.7	0.2	99.2	0.2	16.5
4	сэлбэг материалын	179.2	0.5	57.9	0.1	(121.3)
5	хаягдал төмрын	82.7	0.2	4.3	0.0	(78.4)
6	ханшны	1,078.2	3.2	1,101.8	2.1	23.6
7	бусад	178.1	0.5	1,716.9	3.3	1,538.8
	Дүн	33,784.7	100.0	51,902.9	100.0	18,118.2

- Тайлант онд борлуулалтын орлого урд оны мөн үеэс 53.6 %-иар буюу 18,118.2 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:
  - Алтны борлуулалт урд оны мөн үеэс 10,430.2 м.төгрөгөөр,
  - Борлуулалтын биет хэмжээ урд оноос 155.6 м.тн-оор нэмэгдсэнээс 6,314.8 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.
- Хэдийгээр борлуулалтын орлого өмнөх оноос нэмэгдсэн боловч жингийн зөрүүнээс 276.9 сая төгрөг, нүүрсний илчлэгийн зөрүүнээс 260.4 сая төгрөг, чулуулгийн байдлаас 31.1 сая төгрөг нийт 568.4 сая төгрөгийг алдсан байна. Нийт алдсан мөнгөний 55.7%-ийг Эрдэнэт ДЦС-аас алдсан байна. Харилцагч бүрээр харуулбал /сая.төг/:

Байгууллага	Илчлэг 260.4 сая.төг	Жин 276.9 сая.төг	Чулуулаг 31.1 сая.төг	Дүн 568.4 сая.төг
Дархан ДЦС		104.6 сая.төг		104.6 сая.төг
Эрдэнэт ДЦС	220.3 сая.төг	86.8 сая.төг	9.6 сая.төг	316.7 сая.төг
Эрдэнэт ГОК	20.7 сая.төг	72.5 сая.төг		93.2 сая.төг
Бусад	19.4 сая.төг	13.0 сая.төг	21.5 сая.төг	53.9 сая.төг

## ЗАРДАЛ

- Компани тайлант онд 49,092.2 сая төгрөгний зардал гаргаж ажилласнаас нүүрсний зардалд 71.7%-ийг, алт олборлох үйл ажиллагаанд 10.1%-ийг, удирдлага борлуулалтын зардалд 6.3%-ийг, хүүний зардалд 3.6%-ийг, ЭЗНХ-ийн санд 1.5%-ийг, торгууль гэрээний алдангид 2.2%-ийг, бусад зардалд 4.6 %-ийг тус тус зарцуулсан байна.
- Зардлын төрлөөр нь авч үзвэл:

д/д	зардлын нэр төрөл	2016 он		2017 он		зөрүү сая.төг
		сая.төг	хувь	сая.төг	хувь	
1	Нүүрсний	24,701.4	60.3	35,187.5	71.7	10,486.1
2	Алтны	1,152.7	2.8	4,982.0	10.1	3,829.3
3	удирдлага, борлуулалтын	5,865.4	14.3	3,095.9	6.3	(2,769.5)
4	үйлдвэрийн бусын	479.5	1.2	390.9	0.8	(88.6)
5	сэлбэг борлуулсны	120.9	0.3	43.5	0.1	(77.4)
6	ҮК хөрөнгө актлахад	66.0	0.2	42.4	0.1	(23.6)
7	хүү, бэлэн мөнгөний шимтгэл	622.3	1.5	1,772.1	3.6	1,149.8
8	ЭЗНХ сан	295.6	0.7	747.1	1.5	451.5
9	ханшны зөрүүний	6,041.9	14.7	923.9	1.9	(5,118.0)
10	торгууль, гэрээний алданги	196.9	0.5	1,063.6	2.2	866.7
11	Бусад	1,439.3	3.5	843.3	1.7	(596.0)
	Дүн	40,981.9	100.0	49,092.2	100.0	8,110.3

## 1 ТН НҮҮРСНИЙ ӨӨРИЙН ӨРТӨГ, БОРЛУУЛАЛТЫН ДУНДАЖ ҮНЭ

- 1 тн нүүрсний өөрийн өртөг 3,278.71 төгрөгөөр нэмэгдсэн. Нэмэгдсэн гол шалтгаан нь өртөгт гол нөлөө бүхий зардал сэлбэг материал, ҮХЭ, дугуйн зардал өссөн, мөн хөрс хуулалтын капиталжуулсан хөрөнгийн хорогдол 3.9 тэрбум төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрсөнөөс шалтгаалжээ. Хэдийгээр дээрх зардлууд нэмэгдсэн ч цахилгаан, цалин хөлс, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, нөөцийн татвар, хүүгийн зардал, удирдлага борлуулалтын зардал буурсан харагдаж байна.

1 тонн нүүрсний борлуулалтын дундаж үнэ, 1 тонн нүүрсний өөрийн өртөг /төгрөгөөр/



**1 тн нүүрсний өөрийн өртөгийг хүснэгтээр харуулбал:**

зардлын нэр	2016 он	2017 он	зөрүү төг
Тэсэлгээний зардал	1,631.1	1,706.0	74.9
ШТМ	5,697.1	6,273.5	576.4
Цахилгаан	1,549.7	1,198.6	(351.1)
Цалинхөлс	7,041.2	6,991.8	(49.4)
НДШимтгэл	918.0	922.0	3.9
ҮХЭлэгдэл	5,088.1	6,710.4	1,622.3
Сэлбэг материал	2,330.3	3,890.9	1,560.6
Уур дулаан	542.9	566.3	23.3
Харуулын зардал	481.0	489.5	8.4
Бусдаар гүйцэтгүүлсэн	1,545.0	337.3	(1,207.7)
Нөөцийн татвар	1,594.8	1,011.3	(583.5)
Хүүгийн зардал	1,540.1	1,430.3	(109.8)
Дугуйн зардал	528.8	705.4	176.7
Түрээсийн зардал	1,333.7	1,330.5	(3.2)
Хөрс хуулалтын зардал		4,287.0	4,287.0
Бусад	596.6	2,150.7	1,554.1
Удирдлага, бор зардал	7,697.9	3,393.6	4,304.3)
<b>Дүн</b>	<b>40,116.4</b>	<b>43,395.1</b>	<b>3,278.7</b>

Өртгийн өсөлтөнд нөлөөлсөн голлох зардлуудыг авч үзвэл:

**ТЭСЭЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**

- Тэсэлгээний зардал урд оны мөн үеэс 313.5 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2016 оны 1-5 сард Спейшл Майнинг ХХК, 6-р сараас Монмаг ХХК-тай “тэсэлгээний ажил үйлчилгээ үзүүлэх” гэрээ хийн хамтран ажиллаж байна.
- Тэсэлгээний зардал өссөн гол нөлөөлөл нь уулын цулын хэмжээ өмнөх оноос 489.6 м.м<sup>3</sup> буюу 43.4%-иар өссөнөөс зардал 470.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

**ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ЗАРДАЛ**

- 2017 онд 3,755.0 м.литр буюу 5,237.5 сая төгрөгний дизелийн түлш зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 28.0 %-иар буюу 821.6 м.литрээр, үнийн дүнгээр 1,232.3 сая төгрөг буюу 30.8%-иар нэмэгджээ. Нийт түлшний зардлын 67.3%-ийг автосамосвалын, 7.1%-ийг хүнд механизм, 18.2%-ийг ачигчуудын түлш эзэлж байна.
- Уулын ажлын объём нэмэгдтэй холбогдуулан нэмэлт машин техник ажиллуулсанаар түлшний зардал 988.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

үзүүлэлт	х/нэгж	2016 он	2017 он	өөрчлөлтийн хувь
биет хэмжээ	м.л	2,933.4	3,755.0	28.0
үнийн дүнгээр	сая.төг	4,005.2	5,237.5	30.8
дундаж үнэ	төг	1,365.4	1,394.8	2.2

## ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАРДАЛ

Цалингийн фонд урд онтой харьцуулахад 18.9%-иар нэмэгдсэн.

- Нүүрсний үйлдвэрлэлд дунджаар 393 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд урд онд 378 хүнтэй ажилласан нь хүний тоо 15–аар нэмэгдсэн. Хүний тоо нэмэгдсэнээр цалингийн сан 243.3 сая төгрөгөөр,
- Дундаж цалин 14.2%-иар өссөнөөс 793.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. (2016 оны 6 сараас цалин 10.0%-иар нэмэгдсэн.)
- Цалингийн сан нэмэгдсэн боловч орон тоо бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 32 ажилтан цомхотгосноос цалингийн зардал 102.9 сая төгрөгөөр буурсан.

Үзүүлэлт	х/нэгж	2016 он	2017 он	өөрчлөлтийн хувь	зөрүү
цалингийн сан	сая.төг	5,365.1	6,378.5	18.9	1,013.4
д.цалин	м.төг	1,183.1	1,351.4	14.2	168.3


## СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЗАРДАЛ

- Сэлбэг материалын зардал өнгөрсөн оны мөн үеэс 1,774.9 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Комацу, бульдозер, грейдер, цахилгаан болон дизель ачигчуудын сэлбэгийн зардал урд онтой харьцуулахад 1,560.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.

- Сэлбэгийн зардал нэмэгдсэн гол нөлөөлөл нь манай компанид нийлүүлэгдэж буй комацу автосамосвалуудын сэлбэгийн үнэ нэмэгдсэн, мөн зарим тоног төхөөрөмжид капитал засвар хийсэнтэй холбоотой. Тухайлбал: 1 ширхэг моторын ээлж 66.5 сая төгрөг, 1 ширхэг мотор 597.5 сая төгрөг, 1 ширхэг кардан гол 20.3 сая төгрөг, 1 ширхэг тахир гол 32.2 сая төгрөг, 1 ширхэг турбин 15.4 сая төгрөг байх жишээтэй. Комату автосамосвалууд нь 2013 оноос ашиглалтанд орсон бөгөөд техникийн насжилт нэмэгдэж байгаа (6 дахь жилдээ ажиллаж байгаа) учир сэлбэг материалын зардал жилээс жилд нэмэгдэж байна.

Автосамосвал, ачигч, хүнд механизмуудын сэлбэгийн зардлын өсөлт /хувиар/



## УУР ДУЛААНЫ ЗАРДАЛ

- 2017 онд бүтцийн өөрчлөлтөөс хамааран өөрийн уурын зуухнаас халааж байсан дамжлагын халаалтыг Дулаан Шарын гол ТӨХК-иас авдаг болсоноор дулааны зардал 81.9 сая төгрөгөөр (10,11,12 сар) нэмэгдсэн.

## ДУГУЙНЫ ЗАРДАЛ

- Дугуйны зардал урд оноос 248.3 сая төгрөгөөр нэмэгдсэн. Шалтгаан нь: автосамосвал болон усны Хова, грейдер, ачигч SD 300 ачигчийн дугуйны зах зээлийн нэгжийн үнэ 16.5%-156.7%-иар өссөнөөс 86.7 сая төгрөг нэмэгдсэн.
- Мөн 2017 онд шинээр нэмэгдсэн Белазын дугуй (6 ширхэг)-ны үнэ 68.8 сая төгрөгөөр авсан нь нөлөөлсөн.

## УДИРДЛАГА, БОРЛУУЛАЛТЫН ЗАРДАЛ

- Удирдлага, борлуулалтын зардал өмнөх оноос 2,769.6 сая төгрөгөөр буурчээ.
- Зардлыг хүснэгтээр харуулбал:

зардал	2016 он			2017 он			зөрүү сая төг		
	ЗАХ	БОР	НИЙТ	ЗАХ	БОР	НИЙТ	ЗАХ	БОР	НИЙТ
ШТМ	8.4	140.3	148.6	8.2	2.0	10.2	(0.2)	(138.3)	(138.4)
Цалинхөлс	1,806.8	572.4	2,379.2	1,516.5	215.3	1,731.8	(290.3)	(357.1)	(647.4)
НДШимтгэл	233.2	74.1	307.3	195.9	28.1	224.0	(37.3)	(46.0)	(83.3)
ҮХЭлэгдэл	117.7	29.7	147.4	153.0	30.8	183.8	35.2	1.1	36.4
Сэлбэг, материал	37.5	286.9	324.4	20.9	84.5	105.4	(16.6)	(202.4)	(218.9)
Уур дулаан	55.2	-	55.2	54.8	-	54.8	(0.5)	-	(0.5)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	475.2	528.4	1,003.6	113.1	17.9	131.0	(362.1)	(510.5)	(872.6)
Томилолт	47.3	3.2	50.5	21.6	3.1	24.7	(25.7)	(0.1)	(25.8)
Холбоо	39.9	5.5	45.4	35.4	1.0	36.5	(4.5)	(4.4)	(9.0)
Түрээс	155.4	292.6	448.0	87.7	3.8	91.5	(67.7)	(288.8)	(356.5)
Зар сурталчилгаа	2.3	55.5	57.8	0.9	0.6	1.5	(1.5)	(54.8)	(56.3)
Вагон ашиглалт	-	452.1	452.1	-	75.7	75.7	-	(376.4)	(376.4)
ТУЗ-ийн зардал	323.3	-	323.3	370.0	-	370.0	46.7	-	46.7
Бусад	87.3	35.4	122.6	39.9	15.1	55.0	(47.4)	(20.3)	(67.7)
Нийт	3,389.5	2,476.0	5,865.5	2,617.9	478.0	3,095.9	(771.6)	(1,998.0)	(2,769.6)

## **ГУРАВ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Хамтын удирдлага болох компанийн ТУЗ нь компанийн ойрын болон хэтийн бодлогыг тодорхойлж, компанид үр ашигтай шийдвэр гаргах, үйл ажиллагааг нь хянах, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээ хэлцлүүдэд удирдамж зөвлөмжөөр ханган, компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг явуулж ирлээ.

### **⇒ 2017 оны засаглалын төлөвлөлт**

Тус компани, түүний төлөөлөн удирдах зөвлөл, 2017 онд компанийн засаглалын зарчмуудын дагуу доорхи төлөвлөгөөг боловсруулан батлаж түүнийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө
- Компанийн 2017 оны үйл явдлын хуанли
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод /аудитын хороо, цалин урамшуулалын хороо, нэр дэвшүүлэх хороо/-ын 2017 оны ажлын төлөвлөгөө
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хийх ажил, цаг хугацааны график
- Компанийн 2017 оны сүүлийн хагас, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв зэрэг болно.

Компанийн ТУЗ нь компанийн засаглалын дагуу мөрдөж буй дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

### **⇒ Мэдээ мэдээлэл**

Мэдээ мэдээлэл нь тухайн тайлант хугацааны үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх зарчмыг баримталсан. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хурал хуралдах газар, саналын хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хуулийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз бусад мэдээлэх хэрэгслээр.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж, уг хурлын бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг мэдээлсэн.
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулж, компанийн 5 хувиас дээш багц хувьцаа эзэмшигчид, жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн жилийн ажил, засаглалын тайлан.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /2016.4.25/-ын шийдвэрийн талаарх мэдээлэл
- Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл



- Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл, компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлж тэдний санал зөвлөмжийг хурлын шийдвэрт тусган хэрэгжүүлдэг юм.



*Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан тайлан бүхий товхимол*

⇒ **Хөрөнгийн зах зээл – Компанийн хувьцаа**

52 долоо хоногийн хувьцааны арилжаа ба ханш /2016, 2017 он/

Үзүүлэлт	2016 он	2017 он
Гаргасан хувьцааны тоо	10,170,242	10,170,242
Төрөл	Энгийн	Энгийн
Арилжаалагдсан ширхэг	21,592	274,522
Хаалтын үнэ	2750	2299
Хамгийн их үнэ	4000	2600
Хамгийн бага үнэ	2000	1870
Дундаж үнэ	2323	2271
Арилжааны үнийн дүн	50,164,695	535,461,087

**“Шарын гол” ХК-ийн хувьцааны  
5%-иас дээш багцыг эзэмшигчид**

Нийт хувьцаа 10,170,242

д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1	SHG HOLDINGS 3	2,318,451	22,79
2	SHG HOLDINGS 2	2,028,906	19,94
3	NIHAN HOLDINGS	1,598,889	15,72
4	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1,158,520	11,39
5	SHG HOLDINGS 1	1,142,674	11,23
6	MOGUL RESOURCES	1,000,000	9,83
	ДҮН	9,247,440	90,90

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар “Шарын гол” ХК-ийн хувьцааг нийт 1040 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд үүнээс нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигчийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

⇒ **Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ын дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг.

- “Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” ТУЗ-ийн 2017.03.09-ний өдрийн 08 дугаар тогтоол гарсан.
- Хурлыг 2017.04.27-нд “Баянгол” зочид буудлын хурлын танхимд хуралдуулах шийдвэр гарч хуралдсан.




*Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа 2017.4.27*

Хуралд:

- Компанийн 2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн ажил, засаглалын тайланг мэдээлэх
- Компанийн ТУЗ-ийн 2017 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
- Компанийн ТУЗ-ийн хараат, хараат бус гишүүдийг сонгох
- Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг хэлэлцсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 93,84 хувийн ирцтэй байв.

- Хурлын материалыг Монгол, Англи хэлээр товхимол болгон, хуулийн хугацаанд брокер диллерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл явц, шийдвэрийн талаарх мэдээллийг компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд байрлуулж, хурлын шийдвэр бүхий материалыг хууль журмын хугацаанд СЗХ, МХБ-д хүргүүлсэн байна.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар 2 жилийн хугацаагаар сонгогдсон ТУЗ-ийн гишүүд.



➤ **2017 онд ажилласан Төлөөлөн удирдах зөвлөлийн баг бүрэлдэхүүн**



**Б.Батмөнх**  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**Б.Батбаатар**  
ТУЗ-ийн гишүүн  
Цалин урамшуулалын хорооны  
дарга  
Гүйцэтгэх захирал



**Ж.Батболд**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хорооны гишүүн




**Д.Байлхүү**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хорооны дарга



**Д.Даянбилгүүн**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн




**Жеймс Пассин**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хорооны гишүүн



**Казин Ник**  
ТУЗ-ийн гишүүн  
Цалин урамшуулалын хорооны  
гишүүн



**Фаррел Кеннет**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



**Б.Мянганбаяр**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хорооны дарга  
Цалин урамшуулалын хорооны  
гишүүн



**Л.Батсуурь**  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

⇒ **Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол улсын компанийн тухай хууль, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаа тогтмол явуулж ирлээ.



*Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2017.09.15*

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2017 оны төлөвлөсөн асуудлыг цаг тухайд нь хуралдаж тодорхой шийдвэр гаргаж байлаа. Гишүүдийн оршин суугаа орон зайгаас шалтгаалан онлайн, онлайн бус 2 хэлбэрээр, нийт онлайн хэлбэрээр 8 удаа, онлайн бус хэлбэрээр 4 удаа хуралдсан байна.

2017 онд ТУЗ-ийн нийт 22 тогтоол гарсан. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай
  - Аудитын компани сонгох тухай
  - Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны мэдээлэл, үйл явдлын хуанли, ТУЗ-ийн 2017 оны хуралд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө
  - ТУЗ-ийн дарга сонгох тухай
  - ТУЗ-ийн аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшуулалын хороо байгуулах тухай
  - Компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийг батлах тухай зэрэг удирдлага зохион байгуулалт, засаглалын асуудлаар 8 тогтоол

- Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөний тухай
  - Компанийн 2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай
  - “Нако түлш” ХК-ийн үйл ажиллагааны тухай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээр 4 тогтоол
- Ногдол ашгийн тухай
  - Үндсэн хөрөнгө худалдах, худалдан авах зардал гаргах тухай
  - Аудитлагдсан санхүүгийн тайлан батлах тухай
  - Компанийн 2017 оны сүүлийн хагас, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв батлах тухай зэрэг санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 7 тогтоол
- Харилцах данс нээлгэх тухай
  - Зарим эд хөрөнгө акталж данснаас хасах тухай
  - Сургалтанд хамруулах тухай зэрэг бусад асуудлаар 3 тогтоол гаргаж шийдвэрлэсэн байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн ойрын болон хэтийн бодлогыг тодорхойлж, компанид үр ашигтай байх шийдвэр гаргаж, түүнд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээ хэлцэлүүдэд удирдамж зөвлөмжөөр ханган компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирснийг онцлон тэмдэглэж байна.

➤ **2017 онд ажилласан компанийн гүйцэтгэх удирдлага**



**Б.Батбаатар**  
ТУЗ-ийн гишүүн  
Цалин урамшуулалын хорооны дарга  
Гүйцэтгэх захирал



**Б.Отгонзул**  
Бизнес хөгжил  
хөрөнгө оруулалт  
хариуцсан захирал



**Л.Даваасүрэн**  
Ерөнхий нягтлан  
бодогч



**Ж.Эрдэнэбат**  
Ерөнхий инженер



**Т.Шофер**  
Төр, орон нутгийн  
харилцаа эрхэлсэн  
захирал

⇒ **Компанийн засаглал, үйл ажиллагааны үнэлгээ**

Тус компани нь 2017 оны ажлын амжилтаар Дархан-Уул аймгийн хэмжээнд шалгарч

- Дархан-Уул аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимаас “УУЛ УУРХАЙН ЭНТРЕПРЕНЕР-2017”
- Дархан-Уул аймгийн ажил олгогч эздийн холбооны нэрэмжит уул уурхайн салбарын “ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА” өргөмжлөл
- Шарын гол сумын “ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА”-аар өргөмжлөгдсөн байна.
- Мөн 2016 оны ажлын амжилтаар Монгол улсын засгийн газар Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас шалгаруулж байгаа “ҮНДЭСНИЙ ТОП-150 АЖ АХУЙН НЭГЖ”-д шалгарсан.



Энэхүү үнэлгээ нь тус компани нь тухайн жилд үүргээ зохих ёсоор биелүүлж ажилласны илэрхийлэл байсан юм.





**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 3 сарын 14 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11, компанийн дүрмийн 8, 15, 11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэн батлуулахыг ТУЗ-ийн дарга /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 01

Улаанбаатар

Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2017 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд, тус компани нь 2017 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зохих түвшинд явагдсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Европын сэргээн босголтын хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний үүрэг бүрэн биелээгүйгээс санхүүгийн байдал зохих түвшинд хүрч сайжраагүйг тэмдэглээд:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 02

Улаанбаатар

Компанийн дүрмийн зарим заалтыг хасч,  
шинэчлэн батлах тухай

Компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэр, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 9.3 дахь заалтанд “Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно” гэсэн заалтыг хасч, “Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллахыг хориглох бөгөөд ТУЗ-ийн гишүүн байж болно” гэсэн өөрчлөлт оруулж баталсугай.

ДАРГА

Б.БАТМӨНХ

### **ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

- 9.1 Компанийн Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн /цаашид “Гүйцэтгэх захирал” гэх/ хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон үр дүнгийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 9.2 ТУЗ компанийн Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулах гэрээний үндсэн дээр томилно.
- 9.3 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллахыг хориглох бөгөөд ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.4 Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлан итгэмжлэл авахгүй бөгөөд Компанийн тухай Монгол Улсын хууль болон энэ дүрэмд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - 9.4.1 Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах:
  - 9.4.2 Хараат /охин/ компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн контракт гэрээ байгуулах:
  - 9.4.3 Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах:
  - 9.4.4 Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх:
  - 9.4.5 Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах:
  - 9.4.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах:
  - 9.4.7 Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох:
  - 9.4.8 Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх:
  - 9.4.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ын тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах:
  - 9.4.10 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах:
  - 9.4.11 Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах:
  - 9.4.12 ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар тайлагнах.
- 9.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ цуцалсан буюу цуцлах тухай санал тавьсан тохиолдолд Гүйцэтгэх удирдлагыг шинээр сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд Гүйцэтгэх удирдлагын үүргийг түр гүйцэтгэнэ.
- 9.6 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга, гишүүнд гаргаж болно.

### **АРАВ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 10.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 10.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 10.3 Эрх бүхий албан тушаалтан нь ТУЗ-ийн зөвшөөрснөөр бусад тохиолдолд компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
- 10.4 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг түүнтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ. Хариуцлагыг Компанийн тухай хуульд заасны дагуу хүлээлгэнэ.

### **АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

- 11.1 Компани нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, ХЭ болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрхи газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 03

Улаанбаатар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2018 оны зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

"Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2018 оны ... -р сарын \_\_\_ ний  
өдрийн \_\_\_ дугаар тогтоолын хавсралт

**"Шарын гол" ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв**

(мян.төг)

д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ м.төг
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	345,600.00
2	НДШ	34,560.00
3	Шуудан холбооны зардал	8,124.00
4	Бичиг хэргийн зардал	480
5	Бусдаар гүйцэтгүүлэх	3,500.00
6	Томилолтын зардал	12,000.00
7	Шатахуун	8,415.30
8	Зар сурталчилгаа	3,000.00
9	Засвар үйлчилгээний зардал	5,000.00
10	Даатгал	980.00
11	Хурлын зардал	2,000.00
12	Зочин хүлээн авалт	12,000.00
13	ТУЗ-ийн урамшууллын сан	10,000.00
	<b>Дүн</b>	<b>445,659.30</b>

## “ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

### Ердийн нэр дэвшигчид

#### Батхүүгийн Батмөнх



- 1974 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1996 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль
- 2000 онд АНУ, Калтфорний их сургууль төгссөн
- Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй
- 1996-1998 онд “Бодь лизинг санхүү” ХХК-д дэд захирал
- 2000-2002 онд “Орикс консалтинг” ХХК-д захирал
- 2002-2007 онд “Би Энд Жи Эквипмент” ХХК-д захирал
- 2007-2008 онд “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
- 2008 оноос одоог хүртэл “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна

#### Бадангийн Батбаатар




- 1977 Варшав хотод төрсөн
- 2000 онд Жорж Мейсоны их сургууль төгссөн /бакалавр/
- 2004 онд Жорж Вашингтоны их сургууль төгссөн /магистр/
- Бизнесийн удирдлага, санхүүч мэргэжилтэй
- 2006-2007 онд Мянганы сорилын санд
- 2007-2009 онд “Си Си Пи” ХХК-д
- 2009 оноос одоо хүртэл “Си Би Эм” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан
- 2014 оны 6-р сараас “Шарын гол” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна

#### Жигжидсүрэнгийн Батболд



- 1964 онд Хөвсгөл аймагт төрсөн
- 1986 онд ОХУ-ын Свердловскийн Уралын их сургууль
- 2003 онд Удирдлагын академи тус тус төгссөн
- Уул уурхайн цахилгаан механик инженер, удирдлагын арга зүйч, бизнесийн ухааны магистр
- 1987-1993 онд Дарханы технологийн коллежид багш
- 1993-1998 онд “Арвим” ХХК-д дэд захирал
- 1998-2001 онд Дархан-Уул аймаг дахь төрийн өмчийн хорооны төлөөлөгч
- 2001-2004 онд шороон орд “Майнинг” ХХК-д ерөнхий инженер
- 2005-2007 онд “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал
- 2007 оноос “Шарын гол Энерго” компанийн ерөнхий захирал

### Жеймс Пассин



- 1971 онд АНУ, Чикаго хотод төрсөн
- 1994 онд АНУ-ын Сайнт Жонсын их сургуулийг сонгодог уран зохиол болон философийн ухаан бакалаврын зэрэгтэй төгссөн
- 1995-1999 онд Тайпан олон улсын хөрөнгө оруулалтын мэдээ сонины судалгаа хариуцсан захирал, редактор
- 1999 оноос одоо хүртэл “Файрбөрд менежмент” ХХК-д сангийн зохицуулагчаар ажиллаж байна.
- 2000 онд “Файрбөрд” хөрөнгө оруулалтын санг байгуулсан
- 2006 онд Файрбөрд 2 хөрөнгө оруулалтын санг байгуулсан
- 2008 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
- Мөн “Багануур” ХК, “Би Ди Сек” ХК, “Бэрх-Уул” ХК, “Монгол шилтгээн” ХК, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк”-ны ТУЗ-ийн гишүүн

### Болдын Итгэл



- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2005 онд АНУ-ын Иорктауны ахлах сургууль
- 2008 онд АНУ-ын Жорж Мейсоны их сургууль тус тус төгссөн
- Санхүүч мэргэжилтэй
- 2009-2010 онд Хаан банканд теллер, зээлийн эдийн засагч, харилцааны менежер
- 2010-2013 онд “Ньюком” ХХК-д шинжээч, хөрөнгө оруулалтын менежер
- 2013 оноос одоо хүртэл “Нова Терра” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

### Каззин Ник



- 1969 онд АНУ-ын Калифорнид төрсөн
- АНУ-ын Калифорний их сургууль, Ривер Сайд төгссөн
- Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтэн, эдийн засгийн ухааны бакалавр
- 1999-2002 онд “Дүэч Банк”-ны Борлуулалт худалдааны ажилтан
- 2002-2004 онд “Велэм Фарго” банк байгууллагын борлуулалтын ажилтан
- 2006-2009 онд “Фирст Хоризон” банк дэд дарга
- 2009-2012 онд “Си Ар Ти капитал” удирдах захирал
- 2012-2017 онд “Би Ди Сек” ХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
- 2017 оноос одоог хүртэл “Би Ди Сек” ХК-ийн Хөрөнгө оруулагч, зөвлөхөөр ажиллаж байна



### Баатарын Отгонзул



- 1980 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2003 онд Улсын багшийн их сургууль
- 2009 онд Санхүү эдийн засгийн их сургууль тус тус төгссөн
- 2010 онд Малайз Эрнест энд яонг “НББОУС-т, түүнд орсон өөрчлөлт” сертификатын сургалт
- 2011 онд Калифоны Беркелийн их сургууль “Түйцэтгэх удирдлагын чадваржуулалт” сертификат сургалт
- 2012 онд Компанийн Засаглалын Институт “Компанийн засаглал” сертификат сургалт
- 2013 онд Лондон сургалт “Нүүрсний худалдаа, эрсдэлийн менежмент” сертификат сургалт
- Хэл судлаач, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй
- 2003-2010 онд “Би Энд Жи” группийн ерөнхий нарийн бичгийн дарга
- 2005-2010 онд “Шарын гол” ХК-ийн ерөнхийлөгчийн туслах
- 2010-2013 онд “Шарын гол” ХК-ийн оффис менежер, төслийн удирдагч
- 2013 оноос одоо хүртэл “Шарын гол” ХК-ийн Бизнес хөгжил хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.

### Батбаярын Тулга



- 1989 онд Дархан-Уул аймагт төрсөн
- 1994-2004 онд Завхан Тэсийн 10 жилийн дунд сургууль
- 2004-2008 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль тус тус төгссөн
- Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй
- 2008-2009 онд Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
- 2009-2011 онд Төрийн банканд хянан шалгагч, зах зээл үйл ажиллагааны эрсдэл
- 2011-2012 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд эрсдэлийн эдийн засагч
- 2012-2013 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн эдийн засагч
- 2013-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын санхүүжилтийн хэлтсийн дарга
- 2016-2017 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын банкны газрын дарга
- 2017 оноос Үндэсний хөрөнгө оруулалтын банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан

### Жамаагийн Эрдэнэбат



- 1996 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1977 онд Ерөнхий боловсролын дунд сургууль
- 1984 онд Зөвлөлт холбоот улсын Украины Кривой Рог хотын уул уурхайн институт тус тус төгссөн
- 2008 онд ШУТИС-д уул уурхайн магистр сургалт
- Монгол улсын зөвлөх инженер
- Уул уурхайн инженер маркшейдер мэргэжилтэй
- Монгол улсын гавьяат уурхайчин
- 1984 онд хэсгийн маркшейдер
- 1984 онд ерөнхий маркшейдер
- 2003 оноос ерөнхий технологич
- 2012 оноос одоо хүртэл инженерээр ажиллаж байна

### Жүгдэрнамжилын Эрдэмбилэг



- 1976 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1994 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль
- 2003 онд Удирдлагын академи-д суралцаж төгссөн
- Эдийн засагч мэргэжилтэй
- Бизнесийн удирдлагын магистр
- 1998-2004 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн
- 2005-2009 онд “Энержи-Ресус” ХХК-д төслийн менежер
- 2010-2011 онд Эрдэс баялаг эрчим хүчний яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтэст
- 2016 оноос одоо хүртэл “Говь караван” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа
- 2018 оны 3-р сарын 26-ны өдрөөс “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн орлох гишүүнээр түр хугацаагаар сонгогдон ажиллаж байна

### Хараат бус гишүүдэд нэр дэвшигчид

#### Дамбачүлтэмийн Байлхүү



- 1947 онд Увс аймагт төрсөн
- 1978-1982 онд МУИС-ийн эдийн засгийн сургууль
- 1991, 1995 онуудад АНУ-ын Мерландын их сургуульд мэргэжил дээшлүүлсэн
- Эдийн засагч мэргэжилтэй, Монгол улсын гавьяат эдийн засагч
- 1991-1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын комиссын зөвлөх
- 1992-1996 онд Засгийн газрын өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга
- 1996 оноос Төрийн өмчийн хороонд зөвлөх

### Мажигсүрэнгийн Батсүрэн



- 1977 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2001 онд Улаанбаатар дээд сургууль төгссөн
- Хэрэглээний математикч мэргэжилтэй
- “Хай Би Ойл” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

### Батсүхийн Мянганбаяр



- 1987 онд Увс аймагт төрсөн
- 2006 онд АНУ-ын Нью Жерси мужийн Сайнт Бэнэдиктийн сургууль
- 2011 онд Миннесота мужийн Сайнт Жонсын их сургууль тус тус төгссөн
- Математикч мэргэжилтэй
- 2012 онд МХБ-ийн “Үнэт цаасны зах зээл”-ийн түр сургалт
- 2013 онд СЗХ-ны “Компанийн засаглалын сургалт”
- 2013 онд Runge-ийн уул уурхайн сургалтанд хамрагдаж суралцсан
- 2008 онд АНУ-ын Мондо хэвлэлийн компанид оффис менежерээр ажиллаж байсан
- 2011-2015 онд “Си Би Эм” ХХК-д санхүүгийн шинжээч
- 2016 оноос одоо хүртэл “Говь караван” ХХК-д хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна
- Мөн “Хөх ган” ХК, “РЭАБ” ХХК, “Нако түлш” ХК, “Хай Би Ойл” ХК, “И-Транс” ХК-нуудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг.

### Гэрэлийн Хулан



- 1985 онд Токио хотод төрсөн
- 2000 онд Японы “Шото” дунд сургууль
- 2004 онд Японы “Кокусан” ахлах сургууль
- 2008 онд Японы Азийн их сургууль тус тус төгссөн
- Гадаад харилцааны мэргэжилтэй
- 2011-2013 онд “Солонго Эко Кампинг” ХХК-ийн ерөнхий захирал
- 2014-2018 онд “Интернационал Смарт Акуа Калча” ЛИСАК/ ерөнхий менежер
- 2017-2018 онд “Данфийн ГХО” ХХК гүйцэтгэх захирлаар одоо хүртэл ажиллаж байна

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2018.04.26

дугаар 04

Шарын гол

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн  
ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт,  
хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

-  
-  
-  
-  
-  
-

Хараат бус гишүүнд

-  
-  
-

нарыг

2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 2 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Ногдол ашгийн тухай Г

“Шарын гол” ХК-ийн 2017 оны нүүрс борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 120 хувь, санхүүгийн тайлангаарх татварын дараах ашиг 2,4 тэрбум төгрөг байгаа хэдий ч, хуримтлагдсан алдагдлын хэмжээ 7,6 тэрбум төгрөг, нийт өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 4 хувиар буурч өөрийн хөрөнгийн 60 хувьд хүрсэн боловч компанийн санхүүгийн байдал зохих түвшинд хүрч сайжраагүй байгаа, Тайлант хугацаанд хөрс хуулалт 86 хувийн биелэлттэй байж, сүүлийн 5 жилийн байдлаар хөрс хуулалтын хоцрогдол 5,5 сая шоо метр, уурхайн нийт ашиглалтын хугацаанд хөрс хуулалтын алдагдал 61,0 сая шоо метрт хүрч цаашид уул ажлын нөхцөл хүндэрч, хөрс хуулалтын алдагдал нэмэгдэж байгаа,

Мөн 2014 онд Европийн сэргээн босголтын хөгжлийн банкнаас авсан 5,0 сая ам.долларын зээлийн гэрээний үүргийн биелэгдээгүй дүн 2017 оны жилийн эцсийн байдлаар 14,7 тэрбум төгрөг байгаа нь уг зээлийн гэрээний 3.01 дахь заалтын дагуу зээлдэгч тал ногдол ашиг зарлах, тараах эрх үүсэх боломжгүй,

Дархан, Эрдэнэтийн ДЦС ТӨХК болон Эрдэнэт үйлдвэрийн ДЦС зэрэг томоохон хэрэглэгчдийн өргөтгөлтэй уялдуулан нүүрс олборлолтын хэмжээ 2018-2022 онд жилдээ 1,1-1,6 сая тонн хүрч нийт уулын цулын хэмжээ 2-3 дахин нэмэгдэхээр байгаатай холбогдуулан машин техник, тоног төхөөрөмжийн парк шинэчлэлт хийх шаардлагатай бөгөөд урьдчилсан тооцоогоор энэхүү хөрөнгө оруулалтын хэмжээ 45 тэрбум төгрөг байгаа зэргийг тус тус тэмдэглээд,

Компанийн тухай хуулийн 46.5, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2017 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны  
06 дугаар тогтоолын хавсралт №1

“Шарын гол” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс

### САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....  
Регистрийн дугаар .....  
ХЭ-ийн бүртгэлийн дугаар .....  
Эзэмшиж буй хувьцааны төрөл .....  
Тоо .....

Хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 15:30 цагаас “Корпорейт энд конвеншн  
центр” зочид буудлын хурлын танхимд болно.

д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт. ТУЗ-ийн ажлын тайлан	Тогтоол ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулах тухай	Зарим заалтыг хасах тухай тогтоол				
3	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах	Тогтоол Зардлын төсвийг батлах				
4	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох		Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/			
1	Батхүүгийн Батмөнх					
2	Бадангийн Батбаатар					
3	Жигжидсүрэнгийн Батболд					
4	Жеймс Пассин					
5	Болдын Итгэл					
6	Казин Ник					
7	Баатарын Отгонзул					
8	Батбаярын Тулга					
9	Жүгдэрнамжилын Эрдэмбилэг					
10	Жамаагийн Эрдэнэбат					

<i>Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох</i>		<i>Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/</i>
1	Дамбачүлтэмийн Байлхүү	
2	Мажигсүрэнгийн Батсүрэн	
3	Батсүхийн Мянганбаяр	
4	Гэрэлийн Хулан	
5	<i>Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга</i>	<i>Мэдээлэл тул санал хураахгүй</i>

**Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр 4 дүгээр сарын 26 болно.**

*Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....*

*Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон*

*Тооллогын комиссын дарга .....*

*Гишүүд: .....*

*.....*

*Хүчингүйд тооцсон бол шалтгаан*

*.....*

*.....*

### **Санал авах хуудсын ашиглах санамж**

1. Санал өгөх тэмдэглэл  $\surd$  тэмдэглэнэ.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгоход санал хураах Кумулятив аргыг хэрэглэнэ. Кумулятив аргаар санал өгөх тоо \_\_\_\_\_
  - Тайлбар: саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог 9-өөр үржүүлж нийт саналын эрхийн тоог гаргана. Энэ нь энгийн хувьцааны болон хараат бус гишүүнд өгсөн саналын нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ыг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналын 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс болон “Шарын гол” ХК-ийн УБ дахь Төлөөлөгчийн газар дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгч болно.
4. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-11-311073, 99293913, 99031917 утсаар лавлаж болно.